

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2025/034/НА-СТА-ТЕЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч:  
Я.Самбууням  
Утас:261585 Цахим хаяг: [sambuunyamya@audit.gov.mn](mailto:sambuunyamya@audit.gov.mn)

Санхүү, нийцлийн аудитын газрын  
захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 260512 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261729 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Аудитор: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 261729 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1602

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газрын хооронд 2006 оны 5 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан "Хүмүүнлэгийн тусламж болон техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант онд "Үндсэн хуулийн шүүхийн шинэтгэл ба Ардчилал, хүний эрх" төслийг хэрэгжүүлэх тухай гэрээг байгуулсан байна.

Тус гэрээний зорилт нь Швейцарын Холбооны Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар санхүүжүүлж байгаа төслийг хэрэгжүүлэхэд талууд харилцан дэмжлэг үзүүлэх, талуудын хамтын ажиллагааг дэмжих бөгөөд гэрээ нь 2026 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үргэлжлэхээр байна.

Төсөл хэрэгжсэнээр Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, Цэц хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нөхцөлийг хангах, Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих Цэцийн чадавхыг сайжруулах, Үндсэн хууль, хүний эрх, Үндсэн хуулийн цэцийн талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зэрэг үр дүн гарна гэж төлөвлөсөн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих” хөтөлбөрийн хүрээнд тайлант онд нийт 231 өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авснаас 219 маргааныг хянан шийдвэрлэсэн байна.

## **Бусад асуудал**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар нь 2024 онд 5 зорилт, 29 зорилт, 164 арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Үүнээс 150 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 10 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, 4 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамаараагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

  
Д.ЗАГДЖАВ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	175,297.4	124,143.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,129.7	529.7
33	АВЛАГА	18,803.4	3,035.6
35	БАРАА МАТЕРИАЛ	150,364.3	120,577.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,723,574.0	4,945,155.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,723,574.0	4,945,155.1
39200	Биет хөрөнгө	5,062,213.7	4,396,550.3
39300	Биет бус хөрөнгө	661,360.3	548,604.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,898,871.4	5,069,298.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,898,871.4	5,069,298.2
51	Засгийн газрын хувь оролцоо	5,898,871.4	5,069,298.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,080,671.2	2,080,671.2
51200	Хуримтлагдсан үр дүн	2,260,911.2	1,431,338.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,557,289.1	1,557,289.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,898,871.40	5,069,298.2

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,543,414.7	4,557,245.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	47,002.8
120	Нийтлэг татварын бус орлого	-	47,002.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,543,414.7	4,510,242.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,189,180.7	5,194,547.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,189,180.7	5,194,547.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,993,279.1	4,816,231.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,092,627.8	2,827,615.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,999.2	350,490.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,199.0	65,674.2
2104	Хангамж, бараа материалын зардал	169,452.0	394,414.1
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,388.8	101,749.5
2107	Томилолт, зочны зардал	262,059.4	60,945.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,010.3	176,528.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	886,542.5	838,814.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,901.6	378,315.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(645,766.0)	(637,302.0)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	413,685.1	192,271.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,059,451.0)	(829,573.2)

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,958,322.5	6,958,322.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,958,322.5	6,958,322.50
9	Тайлант үеийн үр дүн	(1,059,451.0)	(1,059,451.00)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,898,871.4	5,898,871.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,898,871.4	5,898,871.40
19	Тайлант үеийн үр дүн	(829,573.20)	(829,573.20)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,069,298.20	5,069,298.20

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,543,414.7	4,510,242.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,543,414.7	4,510,242.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,448,284.2	4,426,112.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,448,284.2	4,426,112.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,252,382.6	4,047,796.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,067,204.3	2,868,167.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,530.4	303,170.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,199.0	65,674.2
2104	Хангамж, бараа материалын зардал	170,147.8	400,482.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,568.1	78,614.9
2107	Томилолт, зочны зардал	262,059.4	60,055.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	297,960.2	181,825.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,713.4	89,806.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,901.6	378,315.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	95,130.5	84,130.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	119,359.7	89,730.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,359.7	89,730.5
2200	Дотоод эх үүсвэрээр	119,359.7	89,730.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(119,359.7)	(89,730.5)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(24,229.2)	(5,600.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,358.9	6,129.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,129.7	529.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,510,242,600.00</b>	<b>4,510,202,156.20</b>	<b>40,443.80</b>	<b>100.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,510,242,600.00</b>	<b>4,510,202,156.20</b>	<b>40,443.80</b>	<b>100.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,137,538,200.00</b>	<b>4,137,526,685.20</b>	<b>11,514.80</b>	<b>100.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,868,167,300.00</b>	<b>2,868,167,300.00</b>	-	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	1,595,242,600.00	1,565,617,471.00	29,625,129.00	98.1
210102	Нэмэгдэл	957,634,300.00	878,551,888.00	79,082,412.00	91.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,347,600.00	229,491,000.00	(105,143,400.00)	184.6
210104	Урамшуулал	190,942,800.00	194,506,941.00	(3,564,141.00)	101.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>303,170,900.00</b>	<b>303,170,900.00</b>	-	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	206,044,400.00	206,044,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	24,253,700.00	24,253,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,238,700.00	12,238,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	12,126,800.00	12,126,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	48,507,300.00	48,507,300.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,674,200.00</b>	<b>65,674,200.00</b>	-	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	47,372,800.00	49,241,330.00	(1,868,530.00)	103.9
210302	Түлш, халаалт	10,410,400.00	11,147,100.00	(736,700.00)	107.1
210303	Цэвэр, бохир ус	7,891,000.00	5,285,770.00	2,605,230.00	66.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>400,741,700.00</b>	<b>400,740,226.20</b>	<b>1,473.80</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	21,013,000.00	21,559,350.00	(546,350.00)	102.6
210402	Тээвэр, шатахуун	320,663,900.00	320,776,594.00	(112,694.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,803,000.00	40,529,052.20	2,273,947.80	94.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,135,400.00	2,135,400.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,126,400.00	15,739,830.00	(1,613,430.00)	111.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>117,425,600.00</b>	<b>117,415,600.00</b>	<b>10,000.00</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,481,900.00	44,471,900.00	10,000.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,893,300.00	3,893,300.00	-	100.0
210604	Урсгал засвар	69,050,400.00	69,050,400.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>60,055,200.00</b>	<b>60,055,159.00</b>	<b>41.00</b>	<b>100.0</b>
210701	Гадаад албан томилолт	58,034,900.00	58,034,859.00	41.00	100.0
210702	Дотоод албан томилолт	2,020,300.00	2,020,300.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>212,719,900.00</b>	<b>212,719,900.00</b>	-	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,981,400.00	129,981,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	78,879,100.00	78,879,100.00	-	100.0
210807	Газрын төлбөр	3,859,400.00	3,859,400.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>109,583,400.00</b>	<b>109,583,400.00</b>	-	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,877,900.00	23,877,900.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85,705,500.00	85,705,500.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>372,704,400.00</b>	<b>372,675,471.00</b>	<b>28,929.00</b>	<b>99.9</b>

<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,745,900.00</b>	<b>3,717,000.00</b>	<b>28,900.00</b>	<b>99.2</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,745,900.00	3,717,000.00	28,900.00	99.2
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>368,958,500.00</b>	<b>368,958,471.00</b>	<b>29.00</b>	<b>100.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	341,087,200.00	341,087,171.00	29.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,871,300.00	27,871,300.00	0.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,510,242,600.00</b>	<b>4,510,202,156.20</b>	<b>40,443.80</b>	<b>100.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,510,242,600.00</b>	<b>4,510,202,156.20</b>	<b>40,443.80</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,510,242,600.00	4,510,202,156.20	40,443.80	100.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>83</b>	<b>83</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>54</b>	<b>57</b>	<b>(3.00)</b>	<b>106.0</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	-	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>44</b>	<b>44</b>	<b>-</b>	<b>100.0</b>
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	8	8	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	0	3	(3.00)	-
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	54	54	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	28	28	-	100.0

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 36.6 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

Тайлант онд худалдан авсан программ хангамжийн эрхийн сунгалтуудтай холбоотой 36.6 сая төгрөгийн зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэлгүйгээр бараа материалын дансанд бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 13.8 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 2.7 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 13.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт:* Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас түрээсээр ашиглаж буй автомашиныг гэрээнд заасан байршил болох авто баазын хашаанд байрлуулалгүйгээр авто зогсоол түрээслэн 1.8 сая төгрөгийн төлбөрийг төсвийн хөрөнгөөс төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийн хөрөнгөөр автомашины авто зогсоолын түрээсийн төлбөрт төлсөн 1.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

*Илрүүлэлт:* Тайлант онд томилолтоор ажилласан 13 албан хаагчид томилолтоор ажиллах хугацаанд 0.9 сая төгрөгийн хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2 дугаар зүйлийн 2.2 "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан хаагчдыг гадаад томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон хоол, унааны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Байгууллагын өөрийн хөрөнгөд бүртгэлгүй буюу Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас түрээсээр ашиглаж байгаа автомашинд шинээр 3 дугуй авахад 6.3 сая төгрөг, явах эд ангид засвар хийж, солих үйлчилгээний зардалд 4.8 сая төгрөг нийт 11.1 сая төгрөгийг байгууллагын урсгал засварын зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.2.3. “эдийн засгийн ангиллаар”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Урсгал засвар “Байгууллагын өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар үйлчилгээний анги энэ ангид хамаарна”, Суудлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх 2024 оны ЗГАБ-ҮГ-24/71 дугаар гэрээний 3.1 “Үйлчлэгч нь автомашины гадаад, дотоод өнгө үзэмж, ариун цэвэр, техникийн аюулгүйн шаардлагыг бүрэн хангаж, зөрчил дутагдалгүй хөнгөн шуурхай үйлчлэх нөхцөлийг 24 цагаар бүрдүүлнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өөрийн хөрөнгөд бүртгэлгүй буюу Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас түрээсээр ашиглаж байгаа автомашинд төсвийн хөрөнгөөр сэлбэг хэрэгсэл бэлтгэхгүй байх.

2. Эд хөрөнгийн тооллогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 40 дүгээр захирамжаар “Эд хөрөнгийн тооллогын комисс” байгуулсан бөгөөд Комиссын гишүүдийн тооллого хийсэн тухай хурлын тэмдэглэл, илтгэх хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.2.4 “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, 72.2.5 “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж, тооллогын комиссын ажлын гүйцэтгэлийг сайжруулан хурлын тэмдэглэл, илтгэх хуудас, анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлж ажиллах.

## **4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд, үнэн зөв, ил тод мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

#### **4.2.1 Албан шаардлага:**

1.Илрүүлэлт: Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын батлагдсан орон тооноос 3 орон тоо хэтрүүлэн хөлсөөр ажиллах гэрээ байгуулан чиг үүргийг давхардуулан ажиллуулж нийт 49.0 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан байна. Үүнд:

- Архив, албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн ажилтныг дадлагажуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, ахмадын хорооны үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг гүйцэтгүүлэхээр нэр бүхий нэг иргэнд 20.0 сая төгрөг;
- Цэцийн үйл ажиллагааны талаарх сурталчилгаа, мэдээлэл бэлтгэх, хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээнд гарч буй буруу ташаа мэдээллийг залруулах, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг гүйцэтгүүлэхээр нэр бүхий нэг иргэнд 20.0 сая төгрөг;
- Тамгын газар болон Судалгааны төвийн чиг үүрэгт хамаарах ажил үүргийг гүйцэтгэх, ажил олгогчоос ирүүлсэн даалгавартай холбоотой харилцааг зохицуулах ажлыг гүйцэтгүүлэхээр нэр бүхий нэг иргэнд 9.0 сая төгрөг;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5. “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.3. “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2. “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2.6. “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоог хэтрүүлж, чиг үүргийг давхардуулан гэрээт ажилтан авч ажиллуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Төсөв захирагч нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хуулийн хугацаанд ирүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

3.Илрүүлэлт: Худалдан авах, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулаагүй, батлуулаагүй, цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй, 210.5 сая төгрөгийн хөрөнгийг ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2. "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.2 "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна", 44.4 "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ", 46 дугаар зүйлийн 46.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1 "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна", 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 3.1 "Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-д заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана", 3.2 "Энэ журмын 3.1-д заасан захиалагчийн тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг төсвийн ерөнхийлөн захирагч энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг хуульд заасан хугацааны дотор боловсруулан батлуулж, цахим системд төлөвлөгөө, тайланг мэдээлж байх, ерөнхий гэрээний аргаар бараа, үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авч байх албан шаардлагыг хүргүүлэв.

#### **4.2.2 Зөвлөмж:**

1.Илрүүлэлт: Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын төсвийн шууд захирагч нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн шууд захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

2.Илрүүлэлт: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2018 оны 70 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т хүчингүй болсон хууль, журмууд тусгагдсан бөгөөд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын (УСНББОУС) шинэчилсэн заалтууд болон шинээр батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын заавар, аргачлалуудыг тусгаагүй бодлогын баримт бичгийг шинэчлээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өнөөг хүртэл шинэчлээгүй нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана. 20 дугаар зүйлийн 20.2.2."аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС-ын заалтууд болон Монгол Улсын хууль, дүрэм, журмын шинэчлэгдсэн заалтыг бүрэн тусган шинэчлэх.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд худалдан авсан программ хангамжийн эрхийн сунгалтуудтай холбоотой зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэлгүйгээр бараа материалаар бүртгэсэн нь нягтлан бодох бүртгэлийн зарчимтай нийцэхгүй байна.	1	36.6	-	-	1	36.6	1	36.6	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>36.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>36.6</b>	<b>1</b>	<b>36.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас автомашин түрээсээр ашиглаж буй цэцийн гишүүд авто зогсоол түрээслэн төлбөрийг төсвийн хөрөнгөөс төлсөн байна.	1	1.8	1	1.8	-	-	-	-
Албан хаагчдын цалин хөлсний тооцооллыг шалгахад, гадаад албан томилолтоор ажилласан 13 албан хаагчдад томилолтоор ажиллах хугацаанд хоол, унааны зардлыг давхардуулан олгосон байна.	1	0.9	1	0.9	-	-	-	-
Байгууллагын өөрийн хөрөнгөд бүртгэлгүй буюу Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас түрээсээр ашиглаж байгаа автомашинд шинээр 3 дугуй авахад 6.3 сая төгрөг, явах эд ангид засвар хийж, солих үйлчилгээний зардалд 4.8 сая төгрөг нийт 11.1 сая төгрөгийг байгууллагын урсгал засварын зардлаас зарцуулсан байна.	1	11.1	-	-	-	-	1	11.1
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 40 дүгээр захирамжаар "Эд хөрөнгийн тооллогын комисс" байгуулсан бөгөөд Комиссын гишүүдийн тооллого хийсэн тухай хурлын тэмдэглэл, илтгэх хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>13.8</b>	<b>2</b>	<b>2.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>11.1</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулаагүй, батлуулаагүй, цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй, ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	210.5	1	210.5	-	-
Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын бүтэц, орон тоонд туссан албан тушаалд давхардуулан 3 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, нийт 49.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.	1	49.0	1	49.0	-	-
Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулаагүй, батлуулаагүй Төрийн аудитын байгууллагад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй байна.	1	-	1	-	-	-
Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын төсвийн шууд захирагч нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.	1	-	-	-	1	-
“Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т хүчингүй болсон хууль, журмууд тусгагдсан бөгөөд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын (УСНББОУС) шинэчилсэн заалтууд болон шинээр батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын заавар, аргачлалуудыг тусгаагүй бодлогын баримт бичгийг шинэчлээгүй байна.	1	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>259.5</b>	<b>3</b>	<b>259.5</b>	<b>2</b>	<b>-</b>